

## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/249/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Дарга, Тэргүүлэх Аудитор: Г.Нандинжаргал  
Утас: 327734 Цахим хаяг: [nandinjargal@audit.gov.mn](mailto:nandinjargal@audit.gov.mn)

Санхүү аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 327734 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Гантөгс  
Утас: 315558 Цахим хаяг: [gantugss@audit.gov.mn](mailto:gantugss@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Цолмон  
Утас: 325093 Цахим хаяг: [tsolmonba@audit.gov.mn](mailto:tsolmonba@audit.gov.mn)

Аудитор: М.Өлзийхишиг  
Утас: 325093 Цахим хаяг: [ulziikhisihiqm@audit.gov.mn](mailto:ulziikhisihiqm@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

|  |                              |
|--|------------------------------|
| 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....  | 2                            |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....                                       | 4                            |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....                                      | Error! Bookmark not defined. |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....                                  | Error! Bookmark not defined. |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                              | Error! Bookmark not defined. |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт ..... | Error! Bookmark not defined. |
| 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....                             | Error! Bookmark not defined. |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН .....  | Error! Bookmark not defined. |
| 4.1 Ерөнхий зүйл .....   | Error! Bookmark not defined. |
| 4.2 Материаллаг байдал .....   | Error! Bookmark not defined. |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....                          | Error! Bookmark not defined. |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал         | Error! Bookmark not defined. |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                 | Error! Bookmark not defined. |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....   | 18                           |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....                         | 19                           |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон улсын стандарт         |
| НТАГ     | Нийслэл дэх Төрийн аудитын газар                      |
| НББОУС   | Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт          |
| НИТХТ    | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар  |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                           |
| НЗДТГ    | Нийслэлийн засаг даргын тамгын газар                  |
| ТЭЗҮ     | Техник эдийн засгийн үзүүлэлт                         |
| НЗД      | Нийслэлийн засаг дарга                                |
| ХАОАТ    | Хүн амын орлогын албан татвар                         |
| ОХУ      | Оросын холбооны улс                                   |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ**  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026-03-13 № 915  
тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ  
ТӨВ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.БАТТУЛГА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 4,301.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь НББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын 2025 оны нийт орлогыг 6,269. сая төгрөг, нийт зардлыг 7,799.0 сая төгрөг байхаар баталснаас гүйцэтгэлээр нийт 10,198.6 сая төгрөгийн орлого орж, 8,122.3 сая төгрөгийн зардал гарсан байна. Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ нь шинээр байгуулагдсантай холбоотойгоор тайлант онд 1,395.8 сая

С.Уламсүрэн /Сайт/Баталсан хугацаа: 2026.03.13 14:26:052013

төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, 1,013,1 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/496 дугаар захирамжаар "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ-т бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж, "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

#### **Бусад асуудал**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны 80 дугаар захирамжаар "хангалттай" гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

  


Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31   |
|---------------|---|------------------------|--------------------------|
| 1.1.1         | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө          |                        | 2,129,034,432.12         |
| 1.1.2         | Дансны авлага                           |                        | 5,428,169.17             |
| 1.1.6         | Бараа материал                          |                        | 496,084,908.80           |
| 1.1.7         | Урьдчилж төлсөн зардал тооцоо           |                        | 1,820,641,751.63         |
| 1.1.11        | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          |                        | <b>4,451,189,261.72</b>  |
| 1.2.1         | Үндсэн хөрөнгө                          |                        | 21,931,751,820.09        |
| 1.2.10        | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      |                        | <b>21,931,751,820.09</b> |
| 1.3           | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               |                        | <b>26,382,941,081.81</b> |
| 2.1.1.1       | Дансны өглөг                            |                        | 4,266,530,799.01         |
| 2.1.1.2       | Цалингийн өглөг                         |                        | 393,869.52               |
| 2.1.1.3       | Татварын өр                             |                        | 60,964,025.00            |
| 2.1.1.4       | НДШ-ийн өглөг                           |                        | 145,002,953.92           |
| 2.1.1.13      | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> |                        | <b>4,472,891,647.45</b>  |
| 2.2           | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>            |                        | <b>4,472,891,647.45</b>  |
| 2.3.1         | Төрийн өмч                              |                        | 23,630,077,000.00        |
| 2.3.9         | Хуримтлагдсан ашиг                      |                        | -1,720,027,565.64        |
| 2.3.11        | <b>Эздийн өмчийн дүн</b>                |                        | <b>21,910,049,434.36</b> |
| 2.4           | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>          |                        | <b>26,382,941,081.81</b> |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                     | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---------------|--|------------------------|------------------------|
| 1             | <b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>         | <b>0.00</b>            | <b>0.00</b>            |
| 2             | Борлуулалтын өртөг                           | 0.00                   | 0.00                   |
| 3             | <b>Нийт ашиг ( алдагдал )</b>                | <b>0.00</b>            | <b>0.00</b>            |
| 4             | Түрээсийн орлого                             | 0.00                   | 0.00                   |
| 5             | Хүүгийн орлого                               | 0.00                   | 12,622,439.51          |
| 6             | Ногдол ашгийн орлого                         | 0.00                   | 0.00                   |
| 7             | Эрхийн шимтгэлийн орлого                     |                        |                        |
| 8             | Бусад орлого                                 | 0.00                   | 6,285,502,576.55       |
| 9             | Борлуулалт, маркетингийн зардал              | 0.00                   | 0.00                   |
| 10            | Ерөнхий ба удирдлагын зардал                 | 0.00                   | 7,501,167,282.75       |
| 11            | Санхүүгийн зардал                            | 0.00                   | 0.00                   |
| 12            | Бусад зардал                                 | 0.00                   | 515,723,055.00         |
| 13            | Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз ) | 0.00                   | 0.00                   |
| 14            | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | 0.00                   | 0.00                   |

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

|      |  |             |                          |
|------|--|-------------|--------------------------|
| 15   | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )                     | 0.00        | 0.00                     |
| 16   | Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз )                | 0.00        | 0.00                     |
| 17   | Бусад ашиг ( алдагдал )  |             |                          |
| 18   | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>                     | <b>0.00</b> | <b>-1,718,765,321.69</b> |
| 19   | Орлогын татварын зардал  | 0.00        | 1,262,243.95             |
| 20   | <b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>                           | <b>0.00</b> | <b>-1,720,027,565.64</b> |
| 21   | <b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b> |             |                          |
| 22   | <b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>                       | <b>0.00</b> | <b>-1,720,027,565.64</b> |
| 23   | Бусад дэлгэрэнгүй орлого   | 0.00        | 0.00                     |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү                       |             |                          |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү                                 |             |                          |
| 23.3 | Бусад олз ( гарз )   |             |                          |
| 24   | <b>Орлогын нийт дүн</b>  | <b>0.00</b> | <b>-1,174,084,968.11</b> |
| 25   | <b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>              |             |                          |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт   | Өмч  | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээн ий нэмэгдэл | Гадаад валютийн хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---------------|--|------|------------------|------------------------|--------------------------------------|------------------------------------|---------------------------|--------------------|----------|
| 1             | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл                                   | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 2             | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 3             | Залруулсан үлдэгдэл  | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 4             | Бусад дэлгэрэнгүй орлого   | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 5             | Өмчид гаргасан өөрчлөлт  | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 6             | Зарласан ногдол ашиг   | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 7             | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )                                  | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 8             | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                              | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 9             | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл                                   | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 10            | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 11            | Залруулсан үлдэгдэл  | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 12            | Бусад дэлгэрэнгүй орлого   | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 13            | Өмчид гаргасан өөрчлөлт  | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |
| 14            | Зарласан ногдол ашиг   | 0.00 | 0.00             | 0.00                   | 0.00                                 | 0.00                               | 0.00                      | 0.00               | 0.00     |

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

|    |   |                       |      |      |      |      |      |                                   |                       |
|----|---|-----------------------|------|------|------|------|------|-----------------------------------|-----------------------|
| 15 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )     | 0.00                  | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 1,720,027,565. <sup>-</sup><br>64 | -1,720,027,565.64     |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00                  | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00                              | 0.00                  |
| 17 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл      | 23,630,077,000.<br>00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 1,720,027,565. <sup>-</sup><br>64 | 21,910,049,434.3<br>6 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт   | 2024 оны 12 дугаар сарын 31 | 2025 оны 12 дугаар сарын 31 |
|---------------|--|-----------------------------|-----------------------------|
|               | Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                         |                             |                             |
| 1             | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                  |                             | 0.00                        |
| 1.1           | Мөнгөн орлогын дүн (+)                                 |                             | 10,198,585,740.55           |
| 1.1.1         | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого           |                             | 3,912,583,164.00            |
| 1.1.2         | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого              |                             | 0.00                        |
| 1.1.3         | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө                 |                             | 0.00                        |
| 1.1.4         | Буцаан авсан албан татвар                              |                             | 0.00                        |
| 1.1.5         | Татаас, санхүүжилтийн орлого                           |                             | 6,285,502,576.55            |
| 1.1.6         | Бусад мөнгөн орлого                                    |                             | 500,000.00                  |
| 1.2           | Мөнгөн зарлагын дүн (-)                                |                             | 8,122,257,317.94            |
| 1.2.1         | Ажиллагсад төлсөн                                      |                             | 3,250,918,113.67            |
| 1.2.2         | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                 |                             | 589,369,115.78              |
| 1.2.3         | Бараа материал худалдан авахад төлсөн                  |                             | 3,577,382,694.98            |
| 1.2.4         | Ашиглалтын зардалд төлсөн                              |                             | 15,236,709.60               |
| 1.2.5         | Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн |                             | 0.00                        |
| 1.2.6         | Хүүгийн төлбөрт төлсөн                                 |                             | 0.00                        |
| 1.2.7         | Татварын байгууллагад төлсөн                           |                             | 232,630,906.41              |
| 1.2.8         | Даатгалын төлбөрт төлсөн                               |                             | 50,000.00                   |
| 1.2.9         | Бусад мөнгөн зарлага                                   |                             | 456,669,777.50              |
| 1.3           | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн     |                             | 2,076,328,422.61            |
| 2             | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ      |                             | 0.00                        |
| 2.1           | Мөнгөн орлогын дүн (+)                                 |                             | 12,820,939.51               |
| 2.1.1         | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого                       |                             | 0.00                        |
| 2.1.2         | Биет бус хөрөнгө борлуулсны орлого                     |                             | 0.00                        |
| 2.1.3         | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого                     |                             | 0.00                        |
| 2.1.4         | Бусад урт хугацаат хөрөнгө буруулсны орлого            |                             | 0.00                        |
| 2.1.5         | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт |                             | 198,500.00                  |
| 2.1.6         | Хүлээн авсан хүүгийн орлого                            |                             | 12,622,439.51               |
| 2.1.7         | Хүлээн авсан ногдол ашиг                               |                             | 0.00                        |
| 2.2           | Мөнгөн зарлагын дүн (-)                                |                             | 0.00                        |
| 2.2.1         | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                    |                             | 0.00                        |
| 2.2.2         | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                  |                             | 0.00                        |
| 2.2.3         | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн                  |                             | 0.00                        |
| 2.2.4         | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн        |                             | 0.00                        |

**Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

|       |  |  |                  |
|-------|--|--|------------------|
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа                           |  | 0.00             |
| 2.3   | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн |  | 12,820,939.51    |
| 3     | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                      |  | 0.00             |
| 3.1   | Мөнгөн орлогын дүн (+)   |  | 39,885,070.00    |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан            |  | 8,885,070.00     |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан   |  | 31,000,000.00    |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив  |  | 0.00             |
| 3.1.4 | Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг                              |  | 0.00             |
| 3.2   | Мөнгөн зарлагын дүн (-)  |  | 1,937,000.00     |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн                         |  | 0.00             |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн                             |  | 1,937,000.00     |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж төлсөн                                 |  | 0.00             |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг   |  | 0.00             |
| 3.2.5 | Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал                          |  | 0.00             |
| 3.3   | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн         |  | 37,948,070.00    |
| 4     | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ                                       |  | 2,127,097,432.12 |
| 5     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл               |  | 0.00             |
| 6     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл              |  | 2,129,034,432.12 |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ                             | 2025 оны батлагдсан төсөв | Гүйцэтгэл    | Хэмнэлт      | Хувь    |
|--------------------------------------|---------------------------|--------------|--------------|---------|
| Үйл ажиллагааны нийт орлого(мян.төг) | 6,269,464.00              | 10,198,585.7 | -3,929,121.7 | 162.7   |
| Төсвийн санхүүжилт                   | 6,269,464.00              | 10,198,585.7 | -3,929,121.7 | 162.7   |
| Үндсэн ба нэмэгдэл цалин             | 8,001,428.00              | 3,250,918.1  | 4,750,509.89 | 40.63   |
| Байгууллагаас төлөх ЭМ, НДШ          | 1,080,192.78              | 233,909.2    | 846,283.62   | 21.65   |
| Хөдөлмөр хамгаалал                   | -                         | 8,821.3      | -8,821.32    | #DIV/0! |
| Бичиг хэрэг                          | -                         | 53,876.8     | -53,876.80   | #DIV/0! |
| Шатахууны зардал                     | 72,000.00                 | 63,471.5     | 8,528.45     | 88.15   |
| Хэвлэлийн зардал                     | 200,000.00                | 78,158.3     | 121,841.67   | 39.08   |

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

|  |              |             |             |        |
|--|--------------|-------------|-------------|--------|
| Даатгалын зардал                                       | 40,000.00    | 20,664.4    | 19,335.64   | 51.66  |
| Техник, хэрэгслийн зардал                              | 19,000.00    |             | 19,000.00   | -      |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал                         | 15,000.00    | 20,602.1    | -5,602.12   | 137.35 |
| Сургалтын зардал                                       | 80,000.00    | 79,305.9    | 694.10      | 99.13  |
| Аян зарлах   | 30,000.00    | 5,600.0     | 24,400.00   | 18.67  |
| Элэгдлийн зардал                                       | 12,504.00    |             | 12,504.00   | -      |
| Программ хөгжүүлэлтийн зардал                          | 250,000.00   | 171,755.6   | 78,244.36   | 68.70  |
| Ажлын байрны засвар<br>үйлчилгээний зардал             | 24,000.00    |             | 24,000.00   | -      |
| Засвар үйлчилгээний зардал                             | 42,000.00    | 125,613.4   | -83,613.40  | 299.08 |
| Түрээсийн зардал                                       | 48,000.00    | 8,947.0     | 39,053.00   | 18.64  |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,<br>үйлчилгээний хөлс       | 60,000.00    | 250,089.2   | -190,089.24 | 416.82 |
| Дамжуулагч төхөөрөмжийн<br>төлбөр IOT                  | 1,059,072.00 | 457,800.0   | 601,272.00  | 43.23  |
| Call сүлжээний төлбөр                                  | 6,000.00     | 5,300.0     | 700.00      | 88.33  |
| Интернэтийн зардал                                     | 24,000.00    | 26,693.2    | -2,693.19   | 111.22 |
| Тээврийн зардал  | 40,000.00    | 815.0       | 39,185.00   | 2.04   |
| Дамжуулагч угаарын хийн<br>мэдрэгчийн серверийн төлбөр | 9,600.00     | 22,041.7    | -12,441.72  | 229.60 |
| Бусад зардал   | 48,000.00    | 31,084.8    | 16,915.18   | 64.76  |
| Ажиллагсдын нийгмийн<br>хамгааллын зардал              | 40,000.00    | 2,778.2     | 37,221.75   | 6.95   |
| Үйл ажиллагааны нийт зардал                            | 7,798,997.59 | 8,122,257.3 | -323,259.73 | 104.14 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,770,776.9 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Ерөнхий удирдлагын зардлыг Борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд 2,808,276.9 мянган төгрөгөөр бүртгэсэн байна
- Тоног төхөөрөмжийн дансанд байгаа угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийн 1,962,500.0 мянган төгрөгийн элэгдэл дутуу байгуулж байгууллагын үр дүнд нөлөөлж байна.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 4,301,633.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчил 4,301,633.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт-1:* Кассын үлдэгдлээр бүртгэсэн 5,609,370.00( таван сая зургаан зуун есөн мянга гурван зуун далан төгрөг 00 мөнгө)-ийг жилийн эцэст тооллого хийж, тооцоог бодоогүй, биет тооллого хийхэд дутагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1. 4/ үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ.; гэж заасантай нийцээгүй гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Бэлэн мөнгөний дутагдлыг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

*Илрүүлэлт-1:* Монголын хэрэглэгчдийн удирдлагын академи ТББ-тай 19,500.0 мянган төгрөгийн сургалтын гэрээ хийсэн боловч гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж

заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал:

**Илрүүлэлт-1:** Санхүүгийн тайланд тусгасан 4,266,530.8 мянган төгрөгийн дансны өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо хийж, актаар баталгаажуулах байх зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт-2:** Сутайн ихэр цэцэг ХХК-тай гэрээ хийгээд ажлын хувцас нийлүүлэхээр болсон боловч нярвын орлогын падаан байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан, хөрөнгийн картад бүртгэл хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга   | Нийт алдаа |                    | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                    | Үүнээс     |                    |              |     | Зөвлөмж |     |
|---|------------|--------------------|-----------------------------------|-----|--------------------------|--------------------|------------|--------------------|--------------|-----|---------|-----|
|   |            |                    |                                   |     |                          |                    | Залруулсан |                    | Залруулаагүй |     |         |     |
|   | Тоо        | Дүн                | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн                | Тоо        | Дүн                | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Ерөнхий удирдлагын зардлыг ББӨ зардалд бүртгэсэн  | 1          | 2,808,277.0        |                                   |     | 1                        | 2,808,277.0        | 1          | 2,808,277.0        |              |     |         |     |
| Тоног төхөөрөмжийн дансанд байгаа угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийн элэгдэл дутуу байгуулж байгууллагын үр дүн нөлөөлж байна. | 1          | 1,962,500.0        |                                   |     | 1                        | 1,962,500.0        | 1          | 1,962,500.0        |              |     |         |     |
| <b>Дүн</b>  | <b>2</b>   | <b>4,770,776.9</b> |                                   |     | <b>2</b>                 | <b>4,770,776.9</b> | <b>2</b>   | <b>4,770,776.9</b> |              |     |         |     |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |          | Үүнээс        |         |                 |          |         |         |                                      |                     |   |     |
|---|-------------|----------|---------------|---------|-----------------|----------|---------|---------|--------------------------------------|---------------------|---|-----|
|   |             |          | Төлбөрийн акт |         | Албан шаардлага |          | Зөвлөмж |         | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн     | Тоо             | Дүн      | Тоо     | Дүн     | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Бэлэн мөнгөний үлдэгдлийн тооллогын баримтгүй, шалгахад бэлэн мөнгө байхгүй бэлэн мөнгөний худалдан авалтаа бүртгээгүй байна  | 1           | 5,609.4  | 1             | 5,609.4 |                 |          |         |         |                                      |                     |   |     |
| Монголын хэрэглэгчдийн удирдлагын академи ТББ-тай сургалтын гэрээ хийсэн боловч гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан байна.                  | 1           | 19,500.0 |               |         | 1               | 19,500.0 |         |         |                                      |                     |   |     |
| Сутайн ихэр цэцэг ХХК-тай гэрээ хийгээд ажлын хувцас нийлүүлэхээр болсон боловч нярвын орлогын падаан байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан, хөрөнгийн картад бүртгэл хөтлөөгүй байна | 1           | 9,993.0  |               |         |                 |          | 1       | 9,993.0 |                                      |                     |   |     |

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

|   |          |                    |          |                |          |                 |          |                    |  |  |  |  |
|---|----------|--------------------|----------|----------------|----------|-----------------|----------|--------------------|--|--|--|--|
| Санхүүгийн тайланд тусгасан дансны өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна | 1        | 4,266,530.8        |          |                |          |                 | 1        | 4,266,530.8        |  |  |  |  |
| <b>Дүн</b>  | <b>4</b> | <b>4,301,663.2</b> | <b>1</b> | <b>5,609.4</b> | <b>1</b> | <b>19,500.0</b> | <b>2</b> | <b>4,276,523.8</b> |  |  |  |  |



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 040/10021354

Улаанбаатар хот

НТАГ-2026/043/НА-17А-01041

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Кассын үлдэгдлээр бүртгэсэн 5,609,370.00 (таван сая зургаан зуун есөн мянга гурван зуун далан төгрөг 00 мөнгө)-ийг жилийн эцэст тооллого хийж, тооцоог бодоогүй, биет тооллого хийхэд дутагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.4-д "Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санхатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад мөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Бэлэн мөнгөний тооллогоор дутагдуулсан 5,609,370.00 (таван сая зургаан зуун есөн мянга гурван зуун далан төгрөг 00 мөнгө) төгрөгийг Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга Б.Баттулга, нягтлан бодогч Цэнд-Аюуш нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ-ын хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дүгээр сарын 29-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дарга Б.Баттулга, нягтлан бодогч Цэнд-Аюуш нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
С.ГАНТӨГС  
М.ӨЛЗИЙХИШИГ

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 5 давхар

1426110297



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 595 /1629/354

Улаанбаатар хот

НТАГ-2026/249/НА-СТА-ОНӨТГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын хэрэгцээнд 19,500,000.00 ( Арван есөн сая таван зуун мянган төгрөг 00 мөнгө)-ний сургалтын гэрээ хийсэн боловч гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн төлбөр төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан ээрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг хийж бүртгэн, санхүүгийн тайланд тусгадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ -ын дарга (Б.Баттулга) нягтлан бодогч (Д.Цэнд-Аюуш) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
С.ГАНТӨГС  
М.ӨЛЗИЙХИШИГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091103